

<https://doi.org/10.65816/jsds.2025.04.010>

Дэлхийн цэрэг-улс төрийн хурцадмал байдал цэргийн зардлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болсон нь

Т.Намсрай¹, Д.Бадам²

¹Техникийн ухааны доктор, профессор

²Хошууч генерал, магистр

ABSTRACT

The aggravation of the military-political situation in the world leads to an increase in military spending in most countries of the world. The situation also affects the expansion of military production and the increase in exports and imports of weapons on the global arms market.

Keywords: *military-political situation, aggravation of the situation, military spending, military production, exports and imports of weapons, global arms market.*

Батлан хамгаалах ба олон улсын харилцааны асуудлаар дүн шинжилгээ хийж судалдаг дэлхийн эрдэм шинжилгээний байгууллагууд, тухайлбал, Стокгольмын энх тайван судлах хүрээлэн (SIPRI), Осло дахь Энх тайван судлах хүрээлэн” (PRIO), АНУ-ын “Дайн судлалын хүрээлэн” (ISW), ОХУ-ын ЗХЖШ-ын академийн “Цэрэг-стратегийн судалгааны төв” зэрэг томоохон эрдэм шинжилгээний байгууллагуудын судлаачид, шинжээчид дэлхийн цэрэг-улс төрийн нөхцөл байдал, улс орнуудад гарч буй дайн зэвсэгт мөргөлдөөн, улс хоорондын зөрчилдөөнийг эрчимтэй судалж байна.

Мөн манай улсын ШУА-ын “Олон улс судлалын хүрээлэн”, “Стратеги судлалын хүрээлэн”, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн холбогдох төвүүдийн эрдэмтэд, шинжээч-мэргэжилтнүүд ч дээр дурдсан чиглэлээр судалгаа хийж байгаа бөгөөд одоогоор цэрэг-улс төрийн хурцадмал нөхцөл байдал нь судалгааны тулгамдсан нэг чиглэл болж байна. .

Цэрэг-улс төрийн нөхцөл байдлын ерөнхий тойм: Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд зэвсэгт мөргөлдөөний тоо улам өссөөр байна. 2022 онд 56 цэргийн мөргөлдөөн гарсан бол 2023 онд 59 болж өссөн байна. 2024 онд дэлхийн 36 улсад 61 мөргөлдөөн гарсан нь дэлхийн хоёрдугаар дайн төгссөнөөс хойш хамгийн олон дайн мөргөлдөөнтэй жил болсон байна[1].

“Хүйтэн дайны төгсгөлөөс (1989) хойш явагдсан зэвсэгт мөргөлдөөний хохирлыг авч үзвэл 2024 онд болсон зэвсэгт мөргөлдөөний улмаас амиа алдсан хүний хохирол нь дөрөв дүгээрт эрэмбэлэгдэж байна. Мөн Орос-Украйн ба Израйль-Пластины хоорондох зэвсэгт мөргөлдөөнд олон мянган хүний амь эрсэдсээр байна. Осло дахь Энх тайван судлах хүрээлэн”-гийн (PRIO) тайланд 2024 онд орос-украины дайнд 76 мянга орчим, Газын зурвас дахь мөргөлдөөнд 26

мянга орчим хүн амиа алдсан гэж дурдсан байна.

Африк тивд 28 улсад төр засаг нь дайтагч талуудын нэг тал болсон дотоодын хямрал мөргөлдөөн (өмнөх арван жилээс 2 дахин их), Ази тивд 17 мөргөлдөөн, Ойрхи Дорнодод 10 мөргөлдөөн тус тус болж, Европ 3, Америк 2 мөргөлдөөнд оролцож байна. Өнөөгийн дэлхий нийтийн анхаарлыг татаж буй цэрэг-улс төрийн хурцадмал сэдэв нь 2022 оны 2 дугаар сарын сүүлчээс эхэлсэн Орос-Украины дайн, 2023 оны 10 дугаар сарын эхээр эхэлсэн Израйл-Палестины мөргөлдөөн болж байна.

“Хятад-Орос-Хойд Солонгос-Иран” гэсэн тэнхлэг бий болж, бие биедээ тусламж дэмжлэг үзүүлж, улмаар Иран ба Хойд Солонгосоос зэвсэг, Хятадаас давхар зориулалттай бүтээгдэхүүнийг Орост нийлүүлж, байна гэх яриа ч гарч байна. Мөн Курск мужийн нутаг дэвсгэрийг украины цэргээс чөлөөлөхөд Хойд Солонгосын цэргийнхэн Оросын талд тусалж оролцсон нь тодорхой болсон.

Ази тивд Хятад дэлхийд тэргүүлэх байдлын төлөө АНУ, түүний холбоотнуудтай өрсөлдөж, Өмнөд Хятадын тэнгис, түүнчлэн Тайваний эргэн тойрон ба Солонгосын хойг дахь нөхцөл байдал улам төвөгтэй болж байна.

Бусад улс орнуудад ч (Мьянмар дахь иргэний дайн, Ардчилсан Конго улсын зүүн хэсэг дэх бослого, Гайти дахь дээрэмчин бүлэглэл засгийн эрхийг хүчээр булаан авсан, Судан дахь гүнзгий хямрал зэрэг) хямралт нөхцөл байдал үүссэн.

2025 онд олон улсын анхаарлын төвд байгаа 10 үйл явдалд Сири ба Судан дахь нөхцөл байдал, Украин ба Европын аюулгүй байдал, Израйл-Палестины мөргөлдөөн, АНУ ба Израйлын Ираны эсрэг ажиллагаа, Гайти дахь нөхцөл байдал, АНУ-Мексикийн харилцаа, Мьянмар дахь хямрал, Солонгосын хойг дахь нөхцөл байдал, Хятад -АНУ хоорондын зөрчилдөөнийг авч үзсэн байна [2].

Дэлхийн янз бүрийн бүс нутагт цэргийн хүчний оролцоотой сөргөлдөөнт тэмцэл бий болох төсөөлөл ажиглагдаж, бүс нутаг дахь цэргийн мөргөлдөөн ба зэвсэглэлээр(бага хүчин чадлын цөмийн зэвсэг, цөмийн бус байлдааны толгой бүхий стратегийн пуужин зэрэг) хөөцөлдөх явдал, үй олноор хөнөөх зэвсэг, терроризм, мансууруулах бодисын бизнес зэрэг аюулгүй байдалд занал учруулах хүчин зүйл дэлгэрэх нь олон улсын тогтвортой байдлыг улам эмзэг болгож болзошгүй гэж шинжээчид үздэг байна.

Улс орнуудын бодлогод эдийн засгийн сонирхол давамгайлах хандлага ажиглагдаж, цэрэг-улс төрийн нөхцөл байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн дунд эрчим хүчний ресурсын төлөөх өрсөлдөөн(жишээлбэл, Арктик) хурцдах төлөвтэй болж байна. Ресурсын төлөөх тэмцэл нь ул орнууд зэвсэглэлээр хөөцөлдөх, улмаар өөрийн ресурст хяналт тавьж хамгаалахын тулд батлан хамгаалах хүчин чадлаа нэмэгдүүлэхэд түлхэж байна.

Дэлхий дахинд хяналтгүй зэвсэглэлээр хөөцөлдөх явдал дахин өрнөж, түүний цар хүрээ зарим бүс нутагт “хүйтэн дайны” үеийн үзүүлэлтээс давсан түшинд хүрэх болж байна. Дэлхий дахинд, ялангуяа мөргөлдөөнтэй бүс нутагт цэрэгжүүлэх үйл явц хурдтай явагдаж байна.

Одоо дэлхийн цэрэг-улс төрийн нөхцөл байдал нэг талаас, олон улсын эдийн

засаг ба улс төрийн харилцааны улам шударга, ардчилсан тогтолцоог бүрдүүлэх талаарх дийлэнх улсын эрмэлзэл, нөгөө талаас, өөрийн үндэсний шийдвэрийн үндсэн дээр НҮБ-ын мандатгүйгээр зэвсэгт хүчнээ хэрэглэх практикаа өргөжүүлэх гэсэн хоёр хандлагаар тодорхойлогдож байна.

Дэлхийн цэрэг улс төрийн хурцадмал байдал нь улсуудын, ялангуяа дайн зэвсэгт мөргөлдөөн, хямралтай болон хамтрагч орнуудын цэргийн зардлыг өсгөх, цэргийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж өргөжүүлэх, дэлхийн зэвсгийн зах дээр зэвсэглэл, цэргийн техникийн экспорт ба импортыг нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Улс орнуудын цэргийн зардлын өсөлт: 2023 оныхтой харьцуулахад 2024 онд дэлхийн нийт цэргийн зардал 9,4 хувиар өсөж, 2,718 их наяд ам.долларт буюу дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2,5 хувьд хүрснийг Стокгольмын энх тайван судлах олон улсын хүрээлэн (SIPRI) тооцоолон гаргасан байна.

Энэ үзүүлэлт нь 1988 оноос хойших хамгийн огцом өсөлт бөгөөд дэлхийн нэг хүнд ногдох цэргийн зардал 334 ам.доллар болсон (1990 оноос хойших хамгийн өндөр) байгаа аж. Дэлхийн цэргийн зардлын 80 хувь (2,185их наяд ам.долл), цэргийн зардлын нийт өсөлтийн 79 хувь нь 15 улсад ногдож байна.

Тухайлбал, АНУ(997 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 37 хувь), Хятад (997 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 37 хувь),Хятад (314 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 12хувь), Орос (140 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 5,5 хувь), Герман (88,5 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 3,3 хувь), Энэтхэг (86,1 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 3,2 хувь), Их Британи (81,8 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 3 хувь), Саудын Арав(80,3 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 3 хувь), Украин (64,7тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 2,4 хувь), Франц (64,7 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 2,4 хувь), Япон (55,3 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 2 хувь), Өмнөд Солонгос (47,6 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 1,7хувь), Израйл(46,5 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 1,7 хувь), Польш (38 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 1,4 хувь), Итали (38 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 1,4 хувь), Австрали (33,8 тэрбум\$ буюу дэлхийн цэргийн зардлын 1,2 хувь) тус тус эзэлж байна [3].

Украины цэргийн төсөв(дотоодын нийт бүтээгдэхүүний 34 хувь) нь дэлхий дэх хамгийн их цэргийн ачаалалтай байж, татварын бараг бүх орлогоо батлан хамгаалах зардалд зарцуулж, цэргийн бус нийгэм-эдийн засгийн асуудлыг үндсэндээ гадаадын тусламжаар шийдвэрлэж байна.

Оросын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх цэргийн зардал 2015 онд 4,9 хувь байсан бол 2024 онд 7,1 хувь, түүнчлэн 2023 оныхтой харьцуулхад оросын 2024 оны төсөв дэх цэргийн зардал 38 хувиар, мөн оны Израйлын төсөвт цэргийн зардал 65 хувиар өссөнийг Украин ба Газын сектор дахь мөргөлдөөнтэй холбон шинжээчид тайлбарласан байна.

Оросын 2024 оны цэргийн төсвийн гол бүрдэл хэсгүүд нь зэвсэглэл, цэргийн техник худалдан авах, зэвсэг үйлдвэрлэгчдийг санхүүжүүлэх, цэргийн алба

хаагчдад олгох зардал зэрэг байгаа аж.

Оросын зэвсэглэлийн экспортын бууралтыг өөрийн улсын зэвсэгт хүчнийхээ хэрэгцээг үндсэн төрлийн зэвсэглэлийн загвараар хангах, олон улсын худалдааны хориг, АНУ, түүний холбоотнуудаас оросын зэвсэг худалдан авагчдад үзүүлж буй дарамт шахалт зэрэг хүчин зүйлтэй холбон авч үзсэн байна.

Сүүлийн 30 жилд Хятад цэргийн зардлаа тасралтгүй өсгөж, өөрийн зэвсэгт хүчиндээ иж бүрэн шинэтгэл хийж байна. 2024 онд л гэхэд үзэгдэлт багатай байлдааны нисэх онгоц, нисгэгчгүй нисэх аппарат ба шумбагч аппаратаа сайжруулж, мөн өөрийн цөмийн чадавхаа үргэлжлүүлэн нэмэгдүүлж, агаар-сансрын ба кибер орон зайн цэргийг байгуулж эхэлсэн.

АНУ-ын “Үндэсний батлан хамгаалах стратеги”-д заасанчлан цэргийн зардлын зорилго нь богино хугацаанд Оросыг тогтоон барих, удаан хугацаанд Хятадыг тогтоон барихад оршдог байна. АНУ-ын 2024 оны цэргийн төсөв нь цөмийн бааздаа сайжруулалт хийх, пуужингийн довтолгооноос хамгаалах, F-35 байлдааны онгоцоор зэвсэглэх, шинэ хөлөг онгоц үйлдвэрлэх, мөн Украин ба Израйлд тусламж үзүүлэхэд түлхүү чиглэсэн байна.

2024 онд НАТО-гийн гишүүн 32 улсын цэргийн зардал 1,506 ам доллар буюу дэлхийн нийт цэргийн зардлын 55 хувийг эзэлсэн бөгөөд европын бүх улс батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлсэн байна. .

2023 онтой харьцуулахад НАТО-гийн эвслийн орнуудын батлан хамгаалах зардал дунджаар 16 хувиар, зарим улсад, тухайлбал, Румынд 43 хувь, Литвад 272 хувиар тус тус өссөн байна.

2014 онд НАТО-гийн орнууд цэргийн зардлаа дотоодын нийт бүтээгдэхүүний(ДНБ) 2 хувьд хүргэхээр тохиролцсон боловч эвслийн орнуудын гуравны хоёр нь л уг үзүүлэлтэд хүрсэн байна. АНУ-ын ерөнхийлөгч Д.Трамп өмнө нь цэргийн зардлаа ДНБ-нийхээ 2 хувь болгох санал гаргаж байсан бол, одоо 5 хувьд хүргэхийг шаардаж байна.

Стокгольмын Энх тайван судлах хүрээлэнгийн шинжээчдийн тооцоолсноор уг үзүүлэлтэд хүрэхийн тулд НАТО-гийн орнууд 663 тэрбум ам.доллар(2024 оныхтой харьцуулахад цэргийн төсвөө 43 хувиар нэмэгдүүлэх) нэмж зарах шаардлага гарах аж.

Цэргийн төсвийг хурдтай өсгөж байгаа нь улс орнуудын үндэсний төсөвт санхүүгийн хүнд дарамт болж байна. Ийм байдлаа бууруулахын тулд зарим улсын засгийн газар бусад салбаруудаас хөрөнгийг батлан хамгаалах чиглэлд шилжүүлэх жишээлбэл, Их Британи гадаадад үзүүлдэг тусламжаа багасгах, Япон зарим бүтээгдэхүүн үйлчилгээний (тамхины) татвараа өсгөх арга хэмжээ авч байна.

Мьянмарт нийгмийн хөтөлбөрүүдээ танах төлөвтэй байгаа нь эдийн засгийн ба нийгмийн ялгаварт байдлыг улам лавшруулж, улмаар хүн амын эмзэг хэсгийн нийгэм-эдийн засгийн байдлыг ноцтой сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй гэж шинжээчид үзсэн байна.

Дэлхийн зэвсгийн зах идэвхэжсэн нь: Сүүлийн жилүүдэд дэлхийн зэвсгийн

захад зэвсэглэл, цэргийн техникийн худалдааны тогтвортой өсөлт ажиглагдаж, цэргийн үйлчилгээ ба зэвсэглэлийн эрэлт хэрэгцээ нь дэлхийн бараг дийлэнх улс орнуудын цэргийн зардлыг нэмэгдүүлэхэд хүргэж байна.

2024 онд дэлхийн зэвсэглэлийн захын худалдаа 111,615 тэрбум ам.долларт хүрсэн нь “хүйтэн дайн” дууссанаас хойших хамгийн өндөр үзүүлэлт болсон тухай Оросын “Дэлхийн зэвсэглэлийн худалдааг шинжлэх төв”-ийн тайланд дурдсан байна.

2025 оны 3 дугаар сарын байдлаар дэлхийн зэвсгийн зах дээр зэвсэглэл, цэргийн техник экспортлогч эхний 10 улс нь АНУ (экспортын орлого 42,3 тэрбум ам.долл, нийт экспортод эзлэх хувь -37,92), ОХУ (экспортын орлого 13,8 тэрбум ам.долл, нийт экспортод эзлэх хувь- 12,32), Франц (экспортын орлого 7,7 тэрбум ам.долл, нийт экспортод эзлэх хувь-6,90), Өмнөд Солонгос (экспортын орлого 5,7 тэрбум, нийт экспортод эзлэх хувь-5,10), Итали (экспортын орлого 5,7 тэрбум ам.долл, нийт экспортод эзлэх хувь -5,10), Герман (экспортын орлого 5,4 тэрбум ам.долл, нийт экспортод эзлэх хувь -4,86), Швед (экспортын орлого 4,3 тэрбум ам.долл, нийт экспортод эзлэх хувь - 3,81), Израйл (экспортын орлого 4,2 тэрбум ам.долл, нийт экспортод эзлэх хувь -3,73), Норвег (экспортын орлого 3,3 тэрбум ам.долл, нийт экспортод эзлэх хувь-2,95), Хятад (экспортын орлого 3,2 тэрбум ам.долл, нийт экспортод эзлэх хувь-2,86) байсан байна [4].

Мөн 2020-2024 онуудад зэвсэг импортлогч эхний 10 улсад Украин (импортын нийт хэмжээний хувь-8,80), Энэтхэг (импортын нийт хэмжээний хувь-8,30), Катар (импортын нийт хэмжээний хувь-6,84), Саудын Арав (импортын нийт хэмжээний хувь-6,80), Пакистан (импортын нийт хэмжээний хувь-4,60), Япон (импортын нийт хэмжээний хувь-3,90), Австрали (импортын нийт хэмжээний хувь-3,50), Египет (импортын нийт хэмжээний хувь-3,30), АНУ (импортын нийт хэмжээний хувь-3,10), Кувейт (импортын нийт хэмжээний хувь-2,90), бусд орнууд (импортын нийт хэмжээний хувь-48,00) гэж тус тус эрэмбэлэгдсэн байна.

2021 онд дэлхийн зэвсэглэл, цэргийн техникийн экспортын хэмжээ 82,942 тэрбум ам.доллар байсан бол 2022 онд 106,185 тэрбум ам.доллар, 2024 онд 111,615 тэрбум ам.долларт хүрсэн нь сүүлийн дөрвөн жилд зэвсэглэлийн зах үлэмж өссөнийг харуулж байна.

Оросын “Дэлхийн зэвсгийн худалдааг шинжлэх төв”-ийн шинжээчид дэлхийн зэвсэглэлийн экспорт, импортын огцом өсөлтийг хэд хэдэн хүчин зүйлтэй, тухайлбал, Украины эргэн тойрны асуудал, Киевт цэргийн тусламж үзүүлэх хүрээнд хуучирсан зэвсэглэл, цэргийн техникээсээ нийлүүлж, оронд нь орчин үеийн, улам өндөр үнэтэй зэвсгийн төрөл загварыг олноор худалдан авч хангалт хийх Барууны орнуудын хандлагатай холбон тайлбарласан байна.

ОХУ дэлхийн 30 улсад зэвсэглэл экспортолдог бөгөөд зэвсэглэл нийлүүлэлтийн дийлэнх (74 хувь) нь Ази-Номхон далайн бүс нутагт, Африк тивд (12 хувь), Европ тивд (7,4 хувь) ба Ойрх Дорнодод (6,4 хувь) тус тус ногддог байна. Оросын зэвсэглэлийн голлох импортлогчид нь Энэтхэг (38%), Хятад (17%), Казахстан (11%) байдаг байна.

Дэлхийн 64 экспортлогч улсын мэдээллийг шинжлэхэд хамгийн их эрэлт хэрэгцээтэй зэвсэглэлийн төрөл нь байлдааны нисэх техник, агаарын довтолгооноос хамгаалах систем, хуягт техник(танк, БМП, БТР, хуягт машин), нисгэгчгүй нисэх аппарат, артиллери болж байна.

Цэргийн үйлдвэрлэлийн сэргэлт: Дэлхийн хэмжээнд цэргийн үйлдвэрлэл эрч хүчээ авч авч, дахин зэвсэглэх үйл явц өрнөж, батлан хамгаалах зардлаа зузаатгаж байгааг зэвсэгт мөргөлдөөн ба хурдан өөрчлөгдөж буй геополитикийн нөхцөл байдалтай уялдаатай гэж үзэх болж байна.

2022 оныхтой харьцуулахад 2023 онд дэлхийн зэвсэг, галт хэрэглэл, цэргийн техник үйлдвэрлэгч томоохон 100 үйлдвэр, компани өөрийн бүтээгдэхүүний худалдааг 6,7 хувиар нэмэгдүүлж, 632 тэрбум ам. долларт хүргэсэн байна.

2022 оноос Орост аж үйлдвэрийг “цэргийн хэрэгцээнд” шилжүүлж, ресурсыг дайчилж, батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлснээр цэргийн үйлдвэрлэл үлэмж өссөн байна. Энэ зорилтын хэрэгжилт нь цэрэг-аж үйлдвэрийн цогцолборт ажиллагсдыг 4,5 саяд хүргэж, улмаар ресурсын давуу байдал нь удаан хугацааны дайн явуулах боломж олгосон, оросын аж үйлдвэрийг цэргийн мөргөлдөөний хэрэгцээнд дасган зохицуулж, цэргийн зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглүүлж чадсан, мөн батлан хамгаалахын зардлаа үлэмж өсгөсөн нь цэргийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхд түлхэц болсон гэж барууны шинжээчид үзсэн байна.

Түүнчлэн Барууны шинжээчдийн үзэж буйгаар 2023-2024 онд оросын аж үйлдвэр нь Т-90М «Прорыв» шинэхэн танкийг жилд 300 орчим үйлдвэрлэх түвшинд хүрсэн, ийм байдлаар үйлдвэрлэлээ үргэлжлүүлэх юм бол 2028 онд жилдээ 1000 орчим хуягт техник, 2025 онд сард дунджаар Х-101 пуужин 46, 9М723 пуужин үйлдвэрлэх боломжтой аж.

Танкны үйлдвэрлэлээ нэмэгдүүлж байгааг цэргийн тусгай операц, мөн Оросын хилийн ойролцоо НАТО-гийн үйл ажиллагааны идэвхжилтэй холбон тайлбарласан байна. Нисгэгчгүй нисэх аппарат (ННА), нисэхийн техник ба пуужинт-артиллерийн зэвсэглэлийн үйлдвэрлэл өсөж байна. 2024 онд Орос янз бүрийн төрөл загварын 1,5 сая гаруй ННА үйлдвэрлэсэн бол 2025 онд 10 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Зөвхөн «Герань-2» дроныг хоногт 500 орчмыг үйлдвэрлэж, уг дроныг угсрах цехүүдийг шинээр байгуулж байна. Орос жилд 36 нэгж Су-34 бөмбөгдөгч үйлдвэрлэх, 2024 оныхтой харьцуулхад «Калашников» концерн пуужинт-артиллерийн галт хэрэглэлийн үйлдвэрлэлийг 60 хувиар өсгөхөөр төлөвлөсөн байна [5].

Ийнхүү олон улсын хориг, дарамттай хэдий ч Орос гадаад улс төрийн тавцанд ба цэргийн тусгай операцын явцад өөрийн зорилтуудаа амжилттай биелүүлэхийн тулд цэргийн хүч чадлаа үргэлжлүүлэн зузаатгаж байна.

Украин дахь цэргийн ажиллагааны явцад Европын орнууд батлан хамгаалахын үйлдвэрүүдээ 3 дахин өргөжүүлж, европын батлан хамгаалахын томоохон концернууд (37 компанийн 150 объект) хоёр жилийн хугацаанд 7 сая км² талбай бүхий үйлдвэрлэлийн хүчин чадлыг шинээр бий болгосон, 2022 оны 2 дугаар сараас европын орнууд галт хэрэглэлийн үйлдвэрлэлээ жилээс жилд нэмэгдүүлж

жилд 300 мянгаас 2 сая орчим хүртэл өсгөсөн байна [6].

Дэлхий дахинд гарч буй шинэ зэвсэгт мөргөлдөөн, хямрал нь улс орнуудын гадаад бодлого дахь цэргийн хүчний үүрэгт үлэмж өөрчлөлт оруулах болж байна. Уг өөрчлөлтийн шинжийг шинээр бий болсон хүчнүүдийн харьцаа, шинэ технологи ба зэвсэгт тэмцэл явуулах хэлбэр аргын хөгжил, олон улсын харилцааны өмнөх тогтолцоо алдагдсан, хүч хэрэглэх арга, хэлбэрийн талаарх тэргүүлэх орнуудын үзэл баримтлалын хувьсал өөрчлөлт тодорхойлж байна.

Бий болж буй дайн зэвсэгт мөргөлдөөн, хямрал, зөрчил бүр өөр өөрийн онцлог шалтгаантай байгаа хэдий ч ерөнхийд нь дараах дүгнэлт хийж болохоор байна.

1. Дэлхийд цэрэг-улс төрийн нөхцөл байдал улам хурцдаж, зарим бүс нутагт тогтворгүй нөхцөл байдал улам даамжрах төлөв ажиглагдаж, зөрчил мөргөлдөөний харилцан уялдаат байдал урьдчилан таамаглахын аргагүй ноцтой үр дагаварт хүргэх эрсдэлийг ихэсгэж, нөхцөл байдлын өрнөлийг төсөөлөхөд төвөгтэй болж байна.

2. Дэлхийн цэрэг-улс төрийн хурцадмал байдал нь улс орнуудын аюулгүй байдалд занал учруулж, улмаар томоохон царааны мөргөлдөөн, болон өргөжих магадлал өндөр байгаа нь дэлхийн нэлээд улс орнуудын цэргийн зардлыг өсгөх, цэргийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж өргөжүүлэх, дэлхийн зэвсгийн зах дээр зэвсэглэл, цэргийн техникийн экспорт ба импортыг нэмэгдүүлэхэд хүргэж байна.

3. Манай улсын тухайд үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх ноцтой хүчин зүйл байхгүй байгаа хэдий ч дэлхийн ба бүс нутгийн цэрэг-улс төрийн нөхцөл байдал маш хурдан өөрчлөгдөж байна. Ийм нөхцөл байдал нь цэрэг-улс төрийн асуудлыг цэрэг-стратегийн ба геополитикийн талаас шинжлэн судалж, зохих дүгнэлт хийж, шаардлагатай бол холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага тавигдаж болох юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1]. Вебсайт:<https://www.dw.com/ru/doklad-cislo-konfliktov-v-mire-dostiglo-maksimuma-s-1946-goda/a-72877643> Число конфликтов в мире достигло максимума с 1946 года)
- [2]. (Вебсайт:<https://www.crisisgroup.org/ru/global/10-conflicts-watch-2025> 10 конфликтов в центре внимания в 2025 году)
- [3]. (Вебсайт:<https://www.rbc.ru/politics/28/04/2025/680ac9169a794781be94b0d6> Эксперты SIPRI назвали страны — лидеры по военным расходам)
- [4]. (Вебсайт:<https://www.tadviser.ru/index.phpru/>Статья:Вооружения_(мировой_рынок))
- [5]. (Вебсайт:<https://anna-news.info/uspehi-vpk-rossii-v-2025-godu/> Успехи ВПК России в 2025 году)
- [6]. (Вебсайт:<https://www.rbc.ru/politics/12/08/2025/689adf109a7947210244bc8b> Страны Европы в три раза ускорили расширение оборонных заводов)